



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 419

Улаанбаатар хот

Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Миг даатгал” ХХК-ийн “Газрын тосны бүтээгдэхүүний даатгал”-ын хавсралтад дурдсан бүтээгдэхүүнийг бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Миг даатгал” ХХК /Б.Мөнххишиг/-д үүрэг болгосугай.

3. Хавсралтад дурдсан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Миг даатгал” ХХК /Б.Мөнххишиг/-д анхааруулсугай.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 12-р сарын 27-ны өдрийн
11.9 –р тогтоолын хавсралт



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Миг даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Газрын тосны бүтээгдэхүүний даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Хөрөнгийн даатгал
4.	Даатгалын зүйл	Бүх төрлийн газрын тосны бүтээгдэхүүн, газрын тосны бүтээгдэхүүний сав, агуулах, шатахуун түгээх станц, ил далд шугам, тоног төхөөрөмж
5.	Даатгалын эрсдэл	Үндсэн эрсдэл: Гал гүймэр, дэлбэрэлт, тэсрэлтэй үүдэлтэй эрсдэл, бүх төрлийн байгалийн эрсдэл, Цахилгааны осол гэмтлээс үүдэлтэй эрсдэл; Нэмэлт эрсдэл: хулгай дээрэм, танхайн сэдэлтэй үйлдэл, сав, тоног төхөөрөмжийн урьдчилан мэдэх боломжгүй осол гэмтлээс үүдэлтэй эрсдэл;
6.	Даатгалын гэрээний хугацаа	1 жил
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	11 бүлэг, 131 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А-19-831 тоот тушаал
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Ч.Батгүшиг
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Даатгал хариуцсан дэд захирал Д.Долгор, андеррайтер Б.Хатанбүүвэй